



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

**2020 оны 3-р сарын 13-20-
ны өдрийн байдлаар**

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 3-р сарын 13-20-ны өдрийн байдлаар

COVID-19 вирус дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Иймд эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр хүргэж байх үүднээс Монголбанкнаас гадаад орчны тоймыг долоо хоног тутам бэлтгэн нийтэд мэдээлж байхаар боллоо. Энэхүү тоймын анхны дугаарыг толилуулж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

COVID-19 нь улс орнуудын эдийн засагт богино хугацаанд цалин, орлого бууруулах, цаашлаад ядуурлыг нэмэгдүүлэх нөлөөтэй байгаа бол удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд хүмүүн капитал болон дэд бүтцийн хөгжилд сөргөөр нөлөөлөхөөр байна (Зураг 1).

Зураг 1. COVID-19-ийн эдийн засагт үзүүлэх нөлөө: боломжит сувгууд



Эх сурвалж: Дэлхийн банк

Тус вирусийн тархалт даамжрах тохиолдолд **дэлхийн эдийн засгийн өсөлт саарах төсөөллийг олон улсын агентлагууд хийж байна**. Тухайлбал, 2019 онд 2.9 хувиар өссөн дэлхийн эдийн засаг вирусийн тархалт пандемик түвшинд хүрэх тохиолдолд энэ онд 1.5 хувь болж буурах төсөөллийг OECD байгууллагаас, 1 хувиар өсөх төсөөллийг EIU байгууллагаас тус тус гаргасан бол, Bloomberg, Mckinsey агентлагууд дэлхийн эдийн засаг өсөлтгүй байхаар төсөөлж байна¹.

¹ Олон улсын агентлагуудын 2020 оны 3-р сард хийсэн төсөөллүүд



COVID-19-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөг олон улсын байгууллагууд 3 боломжит хувилбараар таамаглаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. COVID-19-ийн нөлөө: 3 боломжит хувилбар

Таамаглалууд


| | Хурдан сэргэлт | Глобал сааралт | Пандемик |
|---|--|--|---|
| Дэлхийн эрүүл мэндийн тогтолцоо | ● Хятадтай ижил үр дүнтэй | ● Хятадаас сул үр дүнтэй | ● Хятадаас сул үр дүнтэй |
| Улирлын нөлөө | ● Вирус нь улирлын шинжтэй | ● Вирус нь улирлын шинжтэй | ● Вирус нь улирлын шинжгүй |
| Нас баралтын түвшин | ● Энгийн ханиаднаас бага | ● Энгийн ханиадтай ижил | ● Энгийн ханиаднаас их |
| Зан төлөвийн өөрчлөлт | ● Ихэнх ү/а хэвийн үргэлжлэх | ● Зарим ү/а хэвийн үргэлжлэх | ● Үйл ажиллагаа зогсох |
| Эдийн засгийн хүлээгдэж буй үр дүн | | | |
| | Хурдан сэргэлт | Глобал сааралт | Пандемик |
| БНХАУ | ● Эдийн засаг 2-р улиралд бүрэн сэргэнэ. | ● Эдийн засаг 2-р улиралд бүрэн сэргэнэ. | ● Эдийн засаг 3-р улиралд бүрэн сэргэнэ. |
| Бусад орнууд | ● Европ болон АНУ орнуудын хэрэглээний 1-р улиралд огцом унана. ● Бусад эдийн засагт ялгаатай нөлөөтэй. | ● Европ болон АНУ-ын эдийн засгийн сааралт 2-р улирал хүртэл үргэлжилнэ. | ● Европ болон АНУ-д бүх үйл ажиллагаа зогсох ● Дэлхийн эдийн засгийн хямрал ● Хэрэглэгчийн итгэл 3-р улирал хүртэл сэргэхгүй. |

Эх сурвалж: McKinsey²

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) COVID-19-ийг 3 сарын 11-ний өдөр Пандемик хэмээн зарласнаас хойш олон улсын байгууллагуудын Дэлхийн болон Хятадын эдийн засгийн өсөлтийн таамаглал буурлаа. Хүснэгт 1-т харуулсан үйл ажиллагааны таамаглал дээр үндэслэн олон улсын байгууллагууд өсөлтийн төлөвийг Зураг 2-т харуулсан байдлаар шинэчлээд байна.


Зураг 2. Дэлхийн болон БНХАУ-ын ДНБ-ий өсөлт

Дэлхийн ДНБ-ий өсөлт, хувилбараар, % /2020/ ● Covid-19-с өмнөх үеийн таамаглал ● Хурдан сэргэх хувилбар ● Глобал сааралт хувилбар ● Пандемик хувилбар



² McKinsey: COVID-19: [Implications for business](#)

БНХАУ-ын ДНБ-ий өсөлт, хувилбараар, % /2020/



Эх сурвалж: McKinsey, Bloomberg, OECD

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Хятадын эдийн засаг энэ оны 2-р сарын эцэст үйлдвэрлэлийн нийт потенциалын 60-70 хувиар, 3-р сарын 6-ны өдрийн байдлаар 70-80 хувиар ажиллаж байсан бол 3-р сарын 17-ны байдлаар **80-85 хувиар** ажиллаж байна³.
- Хятадын үндэсний статистикийн хорооноос зарласан мэдээллээр энэ оны эхний 2 сард Хятадын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс **13.5 хувиар буурч, жижиглэн худалдааны борлуулалт 20.5 хувиар агшиж, хөрөнгө оруулалт 24.5 хувиар буурчээ**⁴.
- Экспорт 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 24.9 хувиар, импорт 20.6 хувиар агших төсөөлөлтэй байна. Мөн ажилгүйдлийн түвшин энэ оны 2-р сард **6.2 хувьтай гарсан нь түүхэн дээд түвшин юм**.
- Оны эхний 2 сарын тоон статистик үзүүлэлт ийнхүү Блүүмбергийн шинжээчдийн таамаглалаас даруй 2-3 дахин их бууралттай гарсан⁵ тул 1-р улирлын өсөлтийг -4.3 хувь гэж төсөөлж байсан Блүүмбергийн “богино давтамжтай мэдээлэл суурилсан төсөөлөл (nowcast)” тооцоолол одоо -11 хувь болж огцом буурав.
- COVID-19 вирусийн нөлөө оны эхний хагаст үргэлжилж, эдийн засаг 2020 оны 2-р улиралд 3.7 хувь, 3, 4-р улиралд харгалзан 6, 6 хувиар өссөнөөр **2020 онд Хятадын эдийн засгийн өсөлт жилийн 1.4 хувь хүрэхээр төсөөлж байна** (2-р сарын тоо гарахаас өмнө жилийн өсөлтийн төсөөлөл 5.2 хувь байсан).
- Хятад 1-р улиралд вирусийг хяналтдаа авч эдийн засгийн үйл ажиллагаа хэвийн түвшин рүү ойртож сэргэсэн хэдий ч, Америк болон Европын холбоонд тархалт үргэлжилж байгаагаас 2 дугаар улиралд идэвхжил сул байхаар хүлээгдэж байна. Харин 3-р улирлаас тренд түвшин 6% руу ойртох хүлээлттэй байна.
- Хятадын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн хязгаарлагдмал хэвээр

³ Блүүмберг: “China Insight analysis” articles

⁴ Financial times: [Chinese economy suffers record blow from coronavirus](#)

⁵ Блүүмбергийн шинжээчид аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт оны эхний 2 сард өмнөх

оны мөн үеэс -4.5 хувь хүрнэ гэж таамаглаж байсан бол гүйцэтгэл -13.5 хувь, жижиглэн худалдааны өсөлт -8.5 хувь гэж таамагласан бол -20.5 хувь, хөрөнгө оруулалтын өсөлт -2.4 хувь гэж таамагласан бол -24.5 хувиар тус тус агшив.

байгаа нь хаврын тариалалт хугацаандаа эхлэх, тээврийн хязгаарлалттай нөхцөлд тариаланд хэрэгцээтэй бордоог авахад асуудлууд дээр сорилт үүсэж байна. Хэрэв хаврын тариаланг хангалттай тариалж чадахгүй бол Хятадын хүнсний нөөцийн хүрэлцээ буурах эрсдэлтэйг Economist сэтгүүл онцлов⁶.

- **Хятадын төсвийн бодлого:** Хөнгөлөлттэй зээлийн бодлого баримталж, Хубей мужийн жижиг бизнесүүдийн НӨАТ-ыг тэглэж, бусад мужуудын жижиг бизнесүүдэд 3-р сараас 5-р сарыг дуустал хугацаанд НӨАТ-ыг 3 хувиас 1 хувь болгон бууруулав.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын төв банк зээлийн суурь хүүг 1 нэгж хувиар бууруулсан бөгөөд энэ онд дахин 0.4 нэгж хувиар бууруулах нөөцийн хувийг 1.5-2.0 нэгж хувиар бууруулах төлөвтэй байна. 3 сарын 16-ны өдөр 'дунд хугацааны зээлийн шугам' хэрэгслээр дамжуулан жилийн 3.15% хүүтэй, 1 жилийн хугацаатай 100 тэрбум юань (14.28 тэрбум ам.доллар)-ийг зах зээлд нийлүүлж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжив.

⁶ The Economist: [Covid-19 is making it harder to grow food in China](#)

3 ГЛОБАЛ ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД, ТӨВ БАНКУУДЫН ХАРИУ ҮЙЛДЭЛ

АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ): COVID-19 вирусээс үүдэлтэй хямралаас сэргийлэх зорилгоор 3-р сарын 3-ны өдөр ХНБ-ны хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, репо зах дээрх арилжаагаа нэмэгдүүлээд байсан бол 3-р сарын 15-ны өдөр ээлжит бус хуралдаан хийж, **ХНБ-ны хүүг дахин 1 нэгж хувиар бууруулж 0-0.25 хувьд хүргэлээ**⁷.

Түүнчлэн хамгийн багадаа 700 тэрбум ам.доллар (үүнээс 500 тэрбум нь засгийн газрын үнэт цаас, 200 тэрбум нь моргейжээр баталгаажсан үнэт цаас)-ын үнэт цаас худалдаж авахаа зарлаж, хугацаа нь дуусч эргэн төлөгдөж буй үнэт цаасны үндсэн төлбөрийг бүтнээр нь дахин үнэт цаас худалдан авах хөрөнгө оруулалт болгохоо зарлав. Мөн арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хувийг 0 болгож буулгасан бөгөөд ам.долларын хомсдол үүсэхээс

сэргийлэх зорилгоор бусад таван орны Төв банктай хамтран 84 хоногийн хугацаатай ам.долларын своп шугамыг бүрэн нээхээ мэдэгдэв. Өмнө нь 2008 оны санхүүгийн хямралын үед ХНБ бодлогын хүүгээ өнөөдрийн нам түвшин рүү буулгаж байсан. Гэхдээ хүндрэл удаан үргэлжилсэн тул АНУ-ын эдийн засгийг сэргэтэл буюу 2015 оны эцэс хүртэл хүүгээ нэмэх боломжгүй нөхцөлд байсан билээ.

Ази, Номхон далайн бүсийн Төв банкууд: АНУ-ын ХНБ-ны шийдвэрийн дараа тус бүсийн Төв банкууд **хямралтай тэмцэх шуурхай арга хэмжээ, хөтөлбөрүүдээ зарлав.** БНСУ-ын Төв банк бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар бууруулж, 0.75 хувь буюу түүхэн доод хэмжээнд хүргэв. Шинэ Зеландын төв банк бодлогын хүүгээ 0.75 нэгж хувиар бууруулж 0.25 хувьд хүргэв. Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр тус улсын төв банк өмнө нь худалдан авахаар зарласан үнэт цаасны хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, 12

⁷ CNN: [Federal Reserve cuts rates to zero to support the economy during the coronavirus pandemic](#)



их наяд иенийн (ДНБ-ий 2 хувьтай тэнцэх) үнэт цаас худалдаж авах, вирусийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон бизнесүүдэд зээлийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхээ мэдэгдлээ⁸. Мөн хөрвөх чадварыг дэмжих чиглэлээр бодлогын төлөвийг зөөлрүүлэх хүлээлттэй байна. Харин ОХУ-ын төв банк газрын тосны үнэ огцом буурч, рублийн ханш хурдацтай суларч байгаа тул бодлогын хүүг 6 хувь дээр хэвээр үлдээх шийдвэр гаргаад байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС): 3-р сарын 16-ны өдөр улс орнуудын COVID-19 вирусийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй төсөв, мөнгөний бодлого болон банкны хяналт, зохицуулалтын арга хэмжээнүүдийг судалж, ерөнхий **бодлогын зөвлөмж гаргалаа**. Тус зөвлөмжид эдийн засгийн хохирол урт хугацаанд үргэлжлэхээс сэргийлэх (харьцангуй богино настай энэ хүндрэлийн үед компаниуд үүдээ хааж, иргэд ажилгүй болох тохиолдолд үр дагавар нь удаан, их байх болно)-ийн тулд **төсвийн нэмэлт дэмжлэг (fiscal stimulus) зайлшгүй шаардлагатай**⁹

онцолсон. Төсвийн арга хэмжээ нь нэн тэргүүнд эрүүл мэндийн үйлчилгээ, тусламж зайлшгүй шаардлагатай байгаа чиглэх ёстой гэжээ. Засгийн газар төсвийн дэмжлэг, хамрах хүрээг өргөжүүлж хамгийн их өртөж буй хүмүүс, бизнесүүдэд чиглүүлэх ёстой (цалинтай чөлөө олгох, зорилтот татварын хөнгөлөлтүүд, зорилтот төсвийн дэмжлэгүүд гэх мэт).

Уг зөвлөмжид төв банкууд эдийн засгийн идэвхжлийг дэмжих, олон нийтийн итгэлийг хадгалахын тулд санхүүгийн төлөвийг зөөлрүүлэх, бодит эдийн засагт очих зээлийн урсгал тасалдахгүй байхад анхаарах, дотоодын санхүүгийн зах зээл дэх төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих нь зүйтэй гэжээ. Санхүүгийн зохицуулагчид санхүүгийн тогтвортой байдал, банкны системийн эрүүл байдлыг хадгалах болон эдийн засгийг дэмжих оновчтой балансыг хадгалах нь чухал болохыг онцолсон. Үүнд түр хугацаанд зээлийн эргэн төлөлтийг ачааллыг бууруулах нь бодлого багтсан.

⁸ Financial Times: [Bank of Japan ploughs deeper into stocks to ease coronavirus fears](#)

3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

COVID-19 вирусийн тархалт хурдтай нэмэгдэж буйтай холбоотойгоор дэлхийн эдийн засагт тогтворгүй байдал, эрсдэл ихээр үүсэж ихэнх түүхий эдийн үнэ, ханшид сөргөөр нөлөөлж байна. Улмаар нэг баррель газрын тосны үнэ сүүлийн нэг сарын хугацаанд 2 дахин буурч, 30 ам.доллараас доош оров. Харин Хятадын ган болон аж үйлдвэрүүдийн сэргэлт, төмрийн хүдрийн нийлүүлэлтийн асуудал зэргээс

шалтгаалж төмрийн хүдрийн үнэ харьцангуй өсөх хандлагатай байна.

Газрын тосны үнэ. 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас Brent төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс өндөр дүн хэдий ч дэлхийн хамгийн том газрын тос импортлогч, нийт эрэлтийг тэн хагасыг бүрдүүлдэг Хятад улсад шинэ вирус дэгдсэнтэй холбоотойгоор газрын



тосны үнэ унаж эхэлсэн. Вирусийн халдвар олон оронд эрчимтэй тархаж, улс орнууд хилийн хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж, үүнийг дагаад түлш, шатахууны эрэлт буурч байна. Нөгөө талд, томоохон газрын тос

нийлүүлэгч ОХУ, Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ бууруулахгүй байх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсч, сүүлийн 10 гаруй хоногийн хугацаанд газрын тосны үнэ огцом унаж, сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшинд буюу 30 ам.долларт хүрлээ.



Эх сурвалж: www.investing.com

Зэсийн үнэ. COVID-19 нь Хятадаас гадна Итали, БНСУ, Иран зэрэг улсуудад эрчимтэй тархаж, дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдал, эрсдэлийг бий болгосонтой холбоотойгоор зэсийн ханш огцом унаж эхэллээ. 3-р сарын 17-ны байдлаар зэсийн үнэ тонн тутамд 5305 ам.долларт, улмаар 20-ны өдөр 4855 ам.долларт хүрч оны эхнээс 21 хувиар буураад байна. Өмнөх оны мөн үед зэсийн үнэ 6500 орчим ам.долларт хүрээд байсан бөгөөд 2019 оны эхнээс 10 гаруй хувиар өсөөд байсан үзүүлэлттэй харьцуулахад энэ жил дүр зураг эсрэгээрээ байна.


бөгөөд 2-р сарын дунд үед харьцангуй тогтвортой 1550-1580 ам.долларын хооронд хэлбэлзэж байв. Харин шинэ вирусийн халдвар дэлхийн олон оронд тархаж эхэлсэнтэй зэрэгцээд алтны ханшийн хэлбэлзэл огцом нэмэгдэж 3-р сарын эхээр унц бүр нь 1700 орчим ам.долларт хүрч, 2012 оноос хойших хамгийн дээд түвшинд хүрсэн. Гэхдээ 3 сарын 10-наас эхлээд ихэнх хөгжилтэй улсуудын засгийн газар, төв банкууд COVID-19 вирусийн сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээнүүдийг шийдэмгий авч байгаагаас алтны ханш огцом буурч, 1500 орчим ам.долларт хүрээд байна.

Алтны ханш. АНУ болон Ираны хооронд харилцаанаас үүдэн алтны ханш энэ оны эхэнд хэдхэн өдрийн дотор 1500-аас 1580 ам.долларт хүрсэн


Гэхдээ 2019 оны мөн үетэй харьцуулахад алтны үнэ дунджаар 250 орчим ам.доллараар өндөр байна.



Алтны ханш



Төмрийн хүдрийн үнэ




Эх сурвалж: www.investing.com

Төмрийн хүдэр. 2019 оны 11-р сарын эхэнд 80 ам.долларт хүрч байсан төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн төмрийн хүдрийн нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятадад коронавирустэй холбоотойгоор хөл хорио тогтоосноор


болон 5 орчим хувиар өндөр үзүүлэлт юм.

Нүүрсний үнэ. Ганцмод боомтод нүүрсний үнэ тонн тутамд 880 юань орчим байгаа бөгөөд үнэ энэ түвшинд тогтвортой байж ирсэн нь тээвэрлэлт хийгдэхгүй байсантай холбоотой.

Dow Jones, Nikkei, FTSE индекс



S&P 500 индекс



аж үйлдвэрүүд зогсонги байдалд орж, төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлөв. Ингэснээр 2-р сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. Гэвч, нөгөө талд төмрийн хүдрийн нийлүүлэлт, тээвэрлэлтийн асуудал болон Хятад улсад вирусийн тархалт намжиж, гангийн болон бусад үйлдвэрийн үйл ажиллагаа дахин сэргэсэнтэй зэрэгцэн төмрийн хүдрийн үнэ эргэж өсөж 90 ам.долларт хүрээд байна. Энэ нь өмнөх сар болон өнгөрсөн үеийн мөн үеэс харгалзан 10

Харин Австралийн нүүрсний үнэ бага зэрэг нэмэгдсэн байна. Хятадын дотоодын коксжих нүүрсний үнэ гангийн үйлдвэрлэл сүүлийн өдрүүдэд сэргэснээр тонн тутамд 20-80 юаниар нэмэгдсэн байна. Мөн Хятадын дотоодын авто ачаа тээврийн өртөг бага зэрэг буурсан. Энэ нь 2020 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл ачаа тээврийн замын хураамжийг чөлөөлсөнтэй холбоотой. Нөхцөл байдал энэ хэвээр хадгалагдвал боомтууд дахь нүүрсний нөөц буурах эрсдэлтэй байна.



Түүнчлэн, COVID-19-ын тархалтын нөлөөгөөр **дэлхийн томоохон хөрөнгийн захууд дээр индексүүд унаж байна.** Тухайлбал, 3-р сарын 17-ны байдлаар Dow Jones, Nikkei, FTSE индексүүд 30 орчим хувиар унаад байна. S&P 500 индекс эдийн засгийн богино хугацааны мөчлөгийг илтгэх 850 өдрийн дунджаас доош орж буурсан нь эдийн засагт хямрал

нүүрлэхийн дохио гэж "Boson International Holdings"-ийн шинжээчид үзэж байна. Уг индекс 1987 оны “Хар Даваа гараг”-г хүртэл энэ хязгаараас доош бууж байгаагүй аж. Мөн зах зээл дээрх болгоомжлол, айдсыг илэрхийлэх VIX индекс 2008-09 оны хямралын түвшинг давж, түүхэн дээд түвшинд хүрсэн байна.